



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/281

Арвайхээр

Комисс шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, “б” дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй тоног төхөөрөмж, тавилга, техник хэрэгсэл хүлээж авах ажлын байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн (боловсрол, эрүүл мэнд, соёлын асуудал хариуцсан) мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

-Ашиглагч байгууллагын төлөөлөл болон нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмж, тавилга, техник хэрэгслийн онцлогоос хамаарч мэргэжлийн байгууллагын төлөөлөл

-Нийлүүлэгчийн төлөөлөл

2. Ажлын гүйцэтгэлийг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авахыг комиссын бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Комисс томилох тухай” аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/553 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

011100602